



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 4/100

Номгон

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 133 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”, Онцгой комиссын 2021 оны 46 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Онцгой комиссоос цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд коронавирусын халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх зардалд **44,995,500** төгрөг, Нэгдсэн эмнэлгийн алба хаагчдад олгох урамшууллын зардалд **290,000** төгрөг, нийт **45,285,500** (Дөчин таван сая хоёр зуун наян таван мянга таван зуу)-н төгрөгийг аймгийн Онцгой комиссын Дотоодын хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн зардлаас санхүүжүүлсүгэй.

2.Аймгийн Онцгой комиссын Дотоодын хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн зардлаас гарах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Холбогдох зардлыг дотоодын хандив, тусламжаас санхүүжүүлэхийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлын хэсэг (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621011055



Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 29- ны
өдрийн А/430 дугаар захирамжийн хавсралт.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ДОТООДЫН ХАНДИВ ТУСЛАМЖИЙН МӨНГӨН
ХӨРӨНГӨӨС ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6	7
1	Ковид-19 түргэвчилсэн оношлуур	Аймгийн Онцгой комисст түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх	ширхэг	2727	16,500	44,995,500
2	Нэг удаагийн урамшуулал	Иргэн Д.Баянбилэгээс Нэгдсэн эмнэлэгийн алба хаагчдад олгосон нэг удаагийн урамшуулал	төгрөг	1	290,000	290,000
Нийт зардлын дүн						45,285,500

-----oOo-----